



**2022 оны 1-р
улирлын үйл
ажиллагааны
тайлан**





Гүйцэтгэх захиралын мэндчилгээ

2020 оноос үргэлжилсэн Ковид-19 цар тахлын үр дагавар болон 2022 оны 02 сарын 24-ний өдрөөс эхэлсэн ОХУ болон Украин улс хоорондын дайны нөхцөл байдлын улмаас 2022 эхний улиралд дотоодын эдийн засаг, тэр дундаа барилга бүтээн байгуулалтын салбарын үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээлүүд бий болгосон ч 2022 оны эхний улирлын дунд үеэс үйл ажиллагаанууд эрчимжиж эхэлсэн билээ. "Монгол Базальт" ХК-ийн хувьд энэ хугацаанд ажилтнуудаа тогтвортой ажлын байраар хангах, орлогын эх үүсвэр хангамжийг бууруулахгүй байх бодлогыг нэн тэргүүнд барьж ажилласан юм.

Компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үзүүлэх сөрөг хүчин зүйлүүд болох тээвэр ложистикийн хомсдол, дотоод болон гадаадын бараа материалын үнийн өсөлт, ААН-үүдийн төлбөрийн чадварын бууралт, томоохон төслүүдийн царцалт, валютын ханшийн өсөлт зэрэг асуудлуудтай олон сар нүүр тулсан хэдий ч бид онцгой цаг үеийн бодлого баримталж зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахаар барилгын дулаан тусгаарлагч байгальд ээлтэй чулуун хөвөн хавтан үйлдвэрлэж эхний улиралд 2021 оны хагас жилийн үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлсэн байна.

Цаг үеийн нөхцөл байдалд зохицсон санхүү болон үйлдвэрлэл үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийн компанийн цаашдын үйл ажиллагааг тогтвортой байлгах бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг бид нэн тэргүүний зорилгоо болгон ажиллаж үйл ажиллагааны зардлаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16%-иар бууруулан, борлуулалтын орлогоо 7.4 дахин, өсгөсөн амжилттай байна. . Үндэсний цор ганц үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрлүүд нэмэгдэж үүнийг дагаад санхүүгийн үр дүн үзүүлэлтүүд улам бүр сайжирч хэрэглэгчид болон нийт, хувьцаа эзэмшигчидийнхээ хүлээлтийг давуулан биелүүлэх боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Монгол Базальт ХК-ийн
Гүйцэтгэх захирал
А.Энхгэрэл

Компанийн тухай



Ерөнхий мэдээлэл

Оноосон нэр:

Монгол Базальт ХК

Үйл ажиллагааны

чиглэл:

Чулуун хөвөнгийн
үйлдвэр, үйлдвэрийн
хүчин чадал: Цагт 1.8 тн

Байгуулагдсан огноо:

2007

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар
хот, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Фламинго тауэр,
403
ТООТ

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

Утас, и-майл хаяг:

75114444
monbasalt@rockwool.mn



Удирдлага, хүний нөөц

ТУЗ-ийн дарга:

Л.Ариунболд

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

78



Хувьцааны мэдээлэл

Хувьцааны симбол

код:

MSE:MBW / 544

МХБиржид

бүртгэгдсэн:

2018.04.05

Нийт гаргасан

хувьцаа:

56,417,000 ширхэг

Компанийн танилцуулга

Монгол Базальт ХК нь улсын хөгжлийн түүчээ, эдийн засгийн тэргүүлэх чиглэл бүхий металл бус боловсруулах хүнд үйлдвэрлэлийн салбарт өндөр техник технологийн Евро-стандартын галын аюулгүй байдлыг хангах онцгой тусгаарлагч бүтээгдэхүүний үйлдвэрийг нутагшуулан барилга, дэд бүтэц, эрчим хүчний салбаруудад нийлүүлэн үйл ажиллагаа явуулж байна.

Манай чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал нь ОУ-ын галын А1 зэрэглэлийн стандартад МУ-аас цор ганц нийцдэг тусгай бүтээгдэхүүн бөгөөд байгаль орчин, хүн нийгэмд ээлтэй, нүүрс хүчлийн хий, түүний ул мөрийг бууруулах, эрчим хүч, дулааны хамгийн их хэмнэлт үүсгэх, чанарын эрсдэлгүй үндэсний тогтвортой бүтээн байгуулалтуудыг дэлхийн чанар үзүүлэлтэд нийцүүлж буй стратегийн онц чухал бүтээгдэхүүн юм.

Эрхэм зорилго

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг эрүүл тав тухтай, байгаль дэлхийд ээлтэй, барилга хийцийн эрсдэлгүй, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх, ямагт өсөх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгох.




Accelerate Digital Transformation



Nurture Innovation Culture



Gain Optimal Impact Public Contribution



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Монгол Базальт”ХК-ийн хувьд компанийн засаглал гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үнэ цэнэтэй, үр өгөөжтэй болгохын тулд нийт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талууд хоорондын итгэлцэл, бүхий л харилцаа, үүрэг, хариуцлагын зохистой харьцааг тогтооход чухал ач холбогдолтой үйл явц, тогтолцоо юм.

Компани нь компанийн засаглалын чухал хэмжүүр болох ил тод байдлаа улам сайжруулан төгөлдөржүүлэхээр зорин ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“Монгол Базальт”ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/ бөгөөд ХЭХ нь ээлжит болон ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байна. ХЭХ-ийг Төлөөлөн удирдах зөвлөл болон “Компанийн тухай хууль” болон компанийн дүрэмд заасан үндэслэлээр зарлан хуралдуулж болно.

Гүйцэтгэх удирдлагын баг



Гүйцэтгэх захирал
А.Энхгэрэл



Дэд захирал
П.Батмөнх



Дотоод хяналтын ажилтан
Ц.Байгалмаа



Үйлдвэрийн дарга, Ерөнхий
технологич
П.Баасан-Очир



Ерөнхий менежер
Д.Сайнбаатар



Ерөнхий нягтлан бодогч
Б.Болортуяа



Ерөнхий инженер
Х.Батдэлгэр




Ерөнхий механик инженер
Ж.Сүхбаатар

Хүний нөөц




2019-2021 оны хооронд тогтвортой ажлын байрны өсөлт 15%-30% байгаа бөгөөд шинээр үйлдвэр ашиглалтанд оруулсанаар ажлын байрны тоо хэмжээ 2 дахин өсөх хандлагатай байна. Мөн Монгол Базальт ХК-ийн нийт ажилчдын 30% нь эмэгтэй бөгөөд 90% нь дээд боловсролтой чадварлаг ажиллах хүчин юм.

Боловсролын түвшин




Ажилласан жил



Ажилчдын хүйсийн харьцаа




30%



70%

Ажиллах хүчний харьцуулалт



БҮТЭЭГДЭХҮҮН

BASALTWOOL®
ЧУЛУУН ХӨВӨН
ХАВТАН

BASALTWOOL®
HOUSE ROCK
ХУЙЛМАЛ ХӨНЖИЛ

БАЗАЛИТ FLEX
УЯН, ЗӨӨЛӨН
АКУСТИК ХАВТАН

BASWOOL FARM
ГИДРОПЕНИК
ХӨРСГҮЙ
ТАРИАЛАЛТ

ШҮРШДЭГ
BASALTWOOL®

BASALTWOOL®
ХЭСЭГЧЛЭН
УГСРАХ СЭНДВИЧ

BASALTWOOL®
ТЕРМОБАЗАЛТ-СТУ
ШУГАМ ХООЛОЙН
ДУЛААЛГА

BASALT
ФАЙБЕР
АРМАТУР


The image displays a variety of Basaltwool products including: fireproof insulation blocks, acoustic insulation panels, a roll of House Rock insulation, hydroponic growing mats, a fireproof sandwich panel, pipe insulation, and fiber-reinforced plastic (FRP) rods. A circular inset shows a worker installing insulation in a roof structure. The Basaltwool logo and the Mongolian text 'ШҮРШДЭГ' (Authorized Distributor) are also present.



SDG 17:
Үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох.

Тогтвортой хөгжлийн зорилтууд

SDG 13: Нүүрс хүчлийн хий бага ялгаруулах барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

SDG 7: Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад засвар шинэчлэл хийж эрчим хүчний хэмнэлттэй болсон.

SDG 6: Ашигласан усны нөөцийн сан байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрт саарал усыг хэрэглээнд оруулсан



SDG 13: Үйлдвэрийн гарах хоолойн уудын филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлийн хийн ялгаралыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн

SDG 8: Аюулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулсан

SDG 9: Бат бөх, галд тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх.

SDG 8: Тогтвортой ажлын байр, эдийн засгийн осолтийг дэмжих.


SDG 13: Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг идэвхжүүлэх.

SDG 11: Орлогд нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих.

SDG 7: Эрчим хүчний хэмнэлттэй барилга үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

ТҮҮХИЙ ЭД

SDG 12: Хог хаягдалгүй үр ашигтай үйлвэрлэл.



SDG 3: Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх.

SDG 6: Тариалалтын усны хэрэглээг багасгах.

SDG 2: Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох.

- Тогтвортой хөгжлийн зорилт.
- Бүтээгдэхүүний хэмжүүр.

Онцлох үйл явдал



Монгол Базальт ХК-ийн философи тогтвортой хөгжлийн зорилтуудтай нягт уялдаа холбоотой. Бид 2022 онд Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн ялгаруулж буй нүүрсхүчлийн хий болон агаар орчны бохирдлыг бууруулах дахин дулаалгын төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхэц болох ЭСКО зөвшөөрлөө энэ оны эхний улиралд хүлээн авлаа.

Үзэсгэлэн арга хэмжээ

Улаанбаатар барилга 2022 үзэсгэлэнд оролцон шинээр хэрэгжүүлж буй арматур, хэсэгчлэн угсрах сэндвис хавтан бүтээгдэхүүний мэдээллийг олон нийтэд танилцууллаа.




Амжилтууд

Эрчим хүчний зохицуулах хорооноос “Монгол базальт” ХК-д Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага /ЭСКО/-ын магадлан итгэмжлэлийг олгосныг тус компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэлд гардуулан өгч эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх хүрээнд Эрчим хүч,Барилга,Дэд бүтэц,Аж үйлдвэр,Айл өрхийн хэмжээнд оруулж буй хувь нэмэр,санаачлан хийж буй төслүүдийг өндрөөр үнэллээ.



Цагийн хүрдийн баатрууд-2021: Байгальд ээлтэй үйлдвэрлэл эрхлэгч байгууллагаар Монгол Базальт ХК шалгарлаа.




САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Монгол Базальт ХК нь 2022оны 1-р улиралд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахын төлөө чармайн хичээл зүтгэл гаргаж их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажиллалаа.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг түүхий эд материалын тээвэр болон сэлбэг хэрэгслийн үнийн өсөлтөөс үүдэн нэмэгдсэн хэдий ч борлуулалтын орлогыг өмнөх оны мөн үеэс 7.34 дахин буюу 2.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.


Борлуулалтын орлого /цэвэр/



Олгосон ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох (₮)
2018 он	186,176,100.00	86%	3.30
2019 он	225,668,000.00	68%	4.00
2020 он	162,480,960.00	100%	2.88
2021 он	964,166,530.00	60.2%	17.09

Ногдол ашгийн өсөлт /₮/




Борлуулалт



Монгол Базальт ХК нь 2022оны 1-р улиралд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахын төлөө чармайн хичээл зүтгэл гаргаж их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд 35,301 боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт бүтээгдэхүүний 23.1%-ийг базальт лайт, 18.2%-ийг базальт хауз, 46%-ийг базальт вэнт фасад, 12,5%-ийг базальт техно марк тус тус эзэлж байна.



Хувьцааны мэдээлэл



Хувьцааны ханш

Хаалтын ханш

/2022.03.31/

+47.59₮

172.41₮



220₮


Өмнөх ханш

/2021.12.31/

Хувьцаа эзэмшигчид

■ 5%-иас дээш хувьцаа эзэмшигчид


■ 5%-иас доош хувьцаа эзэмшигчид



Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 238.19₮, доод ханш нь 172.19₮ бөгөөд 2022оны нэг дүгээр улирлын хаалтын ханш 220₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 68.2 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 818.2 мянган ширхэг хувьцааг 177.03 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Хувьцааны ханшийн график



Санхүү байдлын тайлан

МОНГОЛ БАЗАЛТ ХК		2022 оны 03 сарын 31 өдөр	
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)		(мян.төг)	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 03 сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5964104.878	426960.9076
1.1.2	Дансны авлага	4887.22048	2970.74758
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	155.42306	-
1.1.4	Бусад авлага	114042.2029	115143.6355
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	2425087.3	1775124.605
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	653897.6492	2252618.974
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	9162174.673	4572818.869
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	15562794.68	15361322.29
1.2.2	Биет бус хөрөнгө	13503921.06	13353988.48
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29066715.74	28715310.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38228890.41	33288129.64
2	Өр төлбөр ба эздийн өмч	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	181381.6661	261732.8361
2.1.1.2	Цалингийн өглөг	-	2719.21941





Санхүү байдлын тайлан

2.1.1.3	Татварын өр	1104502.921	1024096.962
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	5900141.671	1165515.557
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг	130323.435	837959.7971
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1054622.736	832369.6204
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	180328.3204	190613.6893
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1405.57503	1252.03823
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12		-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8552706.325	4316259.72
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8552706.325	4316259.72
2.3	2. Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч : - төрийн	-	-
2.3.2	- хувийн	5641700	5641700
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	20509765.23	20509765.23
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1429273.949	1429273.949
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2095444.912	1391130.741
2.3.10		-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	29676184.09	28971869.92
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	38228890.41	33288129.64

Орлогын дэлгэрэнгүй тайлан

МОНГОЛ БАЗАЛТ ХК		2022 оны 03 сарын 31 өдөр	
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)		(мян.төг)	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12 сарын 31	2022 оны 03 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,485,330.45	2,466,112.29
2	Борлуулалтын өртөг	7,488,968.62	1,937,348.78
3	Нийт ашиг (алдагдал)	3,996,361.82	528,763.51
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	77,088.12	2,931.92
6	Ногдол ашгийн орлого	-	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	0.00
8	Бусад орлого	3,373.29	1,249.09
9	Борлуулалт маркетингийн зардал	733,235.30	135,530.39
10	Ерөнхий ба удирдлагын зардал	694,761.58	92,962.89
11	Санхүүгийн зардал	507,235.76	50,182.17
12	Бусад зардал	287,401.45	2,041.69
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,138.86	36,724.32
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,856,328.02	288,951.70
19	Орлогын татварын зардал	254,261.98	29,099.34
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,602,066.04	259,852.36
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,602,066.04	259,852.36
23	Бусад дэлгэрэнгүй орлого	1,429,273.95	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	1,429,273.95	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	3,031,339.99	259,852.36
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-





 Address

БГД, 20-р хороо, үйлдвэрийн баруун бүх,
үйлдвэрийн тойруу-132 тоот

 Website

www.Basaltwool.mn

 Telephone

75114444